БАТЛАВ

ЗАХИРАЛ Н. ЦОГБАДРАХ

## 2015 ОНД ЗӨСҮТ-Д ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН БАЙРНЫ ТАСРАЛТГҮЙ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Сургалтын сэдэв | Хугацаа | | Цаг | Хариуцах мэргэжилтэн | Хамрагдах бүлэг |
|---|---|---|---|---|---|---|
| | | улирал | сар | | | |
| **Захиалагт сургалт** | | | | | | |
| 1. | Ажлын байрны стересс түүнээс сэргийлэх аргууд | II | 4 сард | 1 | | |
| 2. | Байгууллагын төлөвлөлт, төлөвлөлтийн түвшин, ангилал, үе шат | II | 5 сард | 1 | | |
| 3. | Төрийн албан хаагчийн ёс зүй | II | 5 сард | 1 | | |
| 4. | Хяналт шинжилгээ үнэлгээний сүүлийн үеийн чиг хандлага, үнэлгээ хийх аргууд | II | 6 сард | 1 | М.Байгалмаа Б.Баатарсүх | Нийт эмч, эмнэлгийн ажилтанууд |
| 5. | Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт | II | 6 сард | 1 | | |
| 6. | Гамшигтай тэмцэх, бэлэн байдлыг хангах, цагийн байдал дээр ажиллах | II | 6сард | 1 | | |
| 7. | Шилэн дансны тухай хууль | III | 9 сард | 1 | | |
| **Биологийн эрсдлийг бууруулах, биоаюулгүй байдал, биохамгаалалын чиглэлээр:** | | | | | | |
| *Био аюулгүй ажиллагаа ба био хамгааллын үндсэн ойлголт:* | | | | | | |
| 8. | Биологийн терроризм | I | 2 сард | 1 | Д.Ганболд | |
| [illegible] | Эмгэг төрүүлэгч биологийн хүчин зүйл | I | 2 сард | 1 | Б.Байгалмаа | |
| 10. | Биологийн аюулгүй байдлын орчин үеийн чиг хандлага | II | 4сард | 1 | Д.Цэрэнноров | Эмч, мэргэжилтнүүд |
| 11. | Биологийн аюлгүй байдлыг хангах тогтолцоо | II | 4 сард | 1 | Н.Цэрэнбүжид | |
| *Биологийн аюулгүй ажиллагааны ерөнхий зарчим:* | | | | | | |
| 12. | Биологийн аюулгүй байдал | II | 4 сард | 1 | Л.Пүрэвдулам | Эмч, мэргэжилтнүүд |
| 13. | Биоэтикийн ерөнхий асуудал, үндсэн ойлголт | II | 4 сард | 1 | Л.Пүрэвдулам | |
| *Биологийн аюултай үйлдлээс ажилтнуудыг хамгаалаах асуудал:* | | | | | | |
| 14. | Хамгаалах байгууламжид бүтээгдэхүүн болон ажилтаныг хамгаалах зарчим | II | 5 сард | 1 | Д.Ганболд | |
| 15. | Хувийн хамгаалах хэрэгсэл | II | 5 сард | 1 | Д.Ганболд | Эмч, мэргэжилтнүүд |
| 16. | Хамгаалах тоног төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх ба ашиглах | II | 5 сард | 1 | Д.Ганболд | |
| *Халдваргүйжүүлэлт:* | | | | | | |
| 17. | Ариутгал, халдваргүйжүүлэлтийн тогтолцоо | II | 6 сард | 1 | Б.Байгалмаа | Эмч, мэргэжилтнүүд |
| 18. | Биологийн болон эмнэлгийн хог хаягдал | II | 6 сард | 1 | Б.Байгалмаа | |
| *Биологийн хүчин зүйл болон хорт бодисыг тээвэрлэх, хадгалах:* | | | | | | |
| 19. | Аюултай хог хаягдлыг зөөвөрлөх | III | 7 сард | 1 | Н.Цэрэнбүжид | Эмч, мэргэжилтнүүд |
| 20. | Казакстан улсын эмгэгтөрөгч нянгийн | III | 7 сард | 1 | Д.Ганболд | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | сангийн үйл ажиллагаа | | | | | |
| *Лабораторийг үйл ажиллагааны чиглэлээр ялгах:* | | | | | | |
| 21. | Микробиологийн лабораторийн зохион байгуулалт | III | 8 сард | 1 | Д.Ганболд | |
| 22. | Судалгаа шинжилгээний лабораторийн биологийн аюулгүй ажиллагааг хангах зарчим | III | 8 сард | 1 | Н.Цэрэнбүжид | Лабораторийн болон бусад эмч, мэргэжилтнүүд |
| 23. | Молекулбиологийн шинжилгээний био аюулгүй ажиллагаа | III | 8 сард | 1 | Б.Байгалмаа | |
| 24. | Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэл болон халдвараас сэргийлэх үеийн био аюулгүй ажиллагаа | III | 8 сард | 1 | Б.Байгалмаа | |
| *Халдварын эрсдэлтэй болон эрсдэл өндөртэй бичил биетэн түүний сэжигтэй материалтай ажиллах үеийн био аюулгүй ажиллагааны онцлог:* | | | | | | |
| 25. | Цусан халдварын үүсгэгчтэй ажиллах үеийн био аюулгүй ажиллагаа | III | 9 сард | 1 | Б.Байгалмаа | Лабораторийн болон бусад эмч, мэргэжилтнүүд |
| 26. | Бруцеллёзын халдварын лабораторийн шинжилгээний биологийн аюулгүй ажиллагаа, био хамгааллын онцлог | III | 9 сард | 1 | Д.Ганболд | |
| 27. | Хулгана тахлын халдварын лабораторийн шинжилгээний биологийн аюулгүй ажиллагаа, био хамгааллын онцлог | III | 9 сард | 1 | Н.Цэрэнбүжид | |
| 28. | Амьтны гаралтай бүтээгдэхүүний биоаюулгүй байдал, мал эмнэлэг-эрүүл ахуйн хяналтын үндсэн зарчим | IV | 10сард | 1 | Н.Цэрэнбүжид | |
| 29. | Урьдчилан сэргийлэх ба оношлогооны бэлдмэлийн үйлдвэрлэлд олон улсын стандартыг нэвтрүүлэх | IV | 10сард | 1 | Н.Цэрэнбүжид | |
| 30. | Лабораторийн туршилтын амьтантай ажиллах үеийн био аюулгүй ажиллагаа | IV | 11сард | 1 | Л.Пүрэвдулам | Биологичид |
| 31. | Эпизоотологийн шинжилгээний үед биологийн аюулгүй ажиллагааг баримтлах | IV | 11сард | 1 | Л.Пүрэвдулам | |
| 32. | Шимэгч судлалын шинжилгээний биологийн аюулгүй ажиллагаа | IV | 11сард | 1 | Д.Цэрэнноров | |
| 33. | Халдваргүйжүүлэх болон мэрэгчгүйтгэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний үед био аюулгүй байдлыг хангах | IV | 12сард | 1 | Д.Цэрэнноров | |
| **Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр:** | | | | | | |
| 34. | Төсөл, хөтөлбөр боловсруулах аргачилал, донор байгууллагуудтай хамтран ажиллах тухай | I | 3 сард | 7 | S.Papageorgiou | Эмч, мэргэжилтнүүд |
| | | | | | | **Нийт: 39 цаг** |
| **Захилагт сургалтын нийт цагийн төлбөр = 7цаг/350 000 төгрөг (1 цагийн 50 000 төгрөг)** | | | | | | |

**Жич:** Сар бүрийн I-IV долоо хоногийн **пүрэв** гаригийн 10 цагт тасралтгүй сургалт тогтмол явагдана.

Хөтөлбөр боловсруулсан:
Сургалт хариуцсан мэргэжилтэн М.Байгалмаа

Хянасан: ЗСТА-ны дарга Б.Баатарсүх

# Авлигын тухай ойлголт сэдэвт сургалт



2015 оны 04-р сарын 02-ний өдөр Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг таниулах зорилгоор "Авлигын тухай ойлголт" сэдэвт сургалтыг төвийн нийт ажилчдад ажлын байрны тасралтгүй сургалтаар зохион байгууллаа. Нийт 30 эмч, мэргэжилтэн хамрагдсан.

Сургалтаар авлигын хэлбэр, шалтгаан, хор хөнөөл, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон авлигын гэмт хэрэг, авлигын эсрэг хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, авлигатай тэмцэж буй гадаад орны туршлага болон дэлхийн авлигын индекс, төрийн байгууллагын хүнд суртал, авлигын талаар мэдлэг мэдээлэл өгч, эмч мэргэжилтнүүдийн асуусан асуултад хариулт өгч, харилцан ярилцсан үр дүнтэй сургалт боллоо.





Энэхүү сургалтаар эмч, мэргэжилтнүүд дараах ойлголтыг авлаа.

1. ЭМЯ-ны хувьд хүнд суртлын индексийн сүүлийн 3 жилийн судалгаагаар тогтмол 1-д явж байна. Энэ нь эрүүл мэндийн салбар иргэдэд үйлчлэх, тэдний эрүүл мэндийг сахин хамгаалах үүргээ гүйцэтгэхдээ хамгийн их хүнд суртал, чирэгдэлтэй үйлчилгээ үзүүлж байна.
2. Ах дүүсэх, тал тохой татах нь авлигын нэг хэлбэр юм байна. Энэ тал дээр анхаарах хэрэгтэй юм байна.
3. Авлига нь төрийн үйлчилгээнд зориулж хуваарилсан эх үүсвэрийг хорогдуулдаг.Авлигын улмаас олсон мөнгө нь хөрөнгө оруулалт руу бараг ордоггүй, тансаг эд хөрөнгө, амьдралын хэв маягт зориулагддаг.
4. Авлигад хэн ч өртөж болзошгүй юм байна.
5. Монгол улс авлигын индексээр дэлхийн улс орнуудын хэдэд жагсаж байгааг болон
6. Авлигад таны үгүй чухал гэдгийг ойлгож авлаа.

Илтгэх хуудас бичсэн: ЭБАТ Э.Үүрийнтуяа

**“Шударга Монгол хүний 7 дадал” сэдэвт сургалт**



Эрүүл мэнд, спортын яам, Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулж буй “Эрүүл мэндийн салбарт инээмсэглэл бэлэглэе” сарын аяны хүрээнд 2015 оны 11-р сарын 23-ны өдөр манай төвд Авлигатай тэмцэх газрын ажилтан, комиссар Д.Балдандорж Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн талаар, “Монголын лектор төв”-ийн сургагч багш Мөнхзаяа “Шударга Монгол хүний 7 дадал” сэдвээр сонирхолтой сургалт зохион байгууллаа. Сургалтад тус төвийн удирдлагууд болон нийт 47 эмч, мэргэжилтэн хамрагдсан.





Сургалтаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, авлига өгөхгүй, авахгүй, өөгшүүлэхгүй, шударга нийгмийг хэрхэн бий болгох талаар мэдлэг мэдээлэл өгч, эмч мэргэжилтнүүдийн асуусан асуултад хариулт өгч, харилцан ярилцсан үр дүнтэй сургалт боллоо.

Илтгэх хуудас бичсэн: ЭБАТ Э.Үүрийнтуяа

**ЭМСЯ, АТГ-тай хамтран сургалт зохион байгууллаа.**



Эрүүл мэнд, спортын яам, Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулж буй "Эрүүл мэндийн салбарт инээмсэглэл бэлэглэе" сарын аяны хүрээнд 2015 оны 11-р сарын 26-ны өдөр Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэсийн сургалт хариуцсан ажилтан н.Дэлгэрбаяр, н.Баярцэцэг нар төвийн хариуцлагатай 12 албан тушаалтанд сургалт явууллаа. Сургалтыг эрүүл мэндийн салбарт төлбөртэй тусламж үйлчилгээ, хандив, давхар ажил эрхлэлттэй холбоотой асуудлын хүрээнд багаар ажиллан эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээлүүдийн талаар харилцан ярилцаж, хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцсон үр дүнтэй хэлбэрээр зохион байгууллаа. Энэ аяны хүрээнд тус сургалтад хамрагдсан нийт байгууллагуудын санал, хүсэлтийг нэгтгээд ЭМСЯ-нд уламжлах юм.





Илтгэх хуудас бичсэн: ЭБАТ Э.Үүрийнтуяа

Хянасан: ЗСТА-ны дарга Б.Баатарсүх